



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 02 сарын 04 өдөр

Дугаар А/78

Номгон

Сум, байгууллагын түүхэн тэгш ой
тэмдэглэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3, 5.4 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 204 дүгээр тогтоолын хоёрдугаар хавсралтаар баталсан “Түүхэн үйл явдлын ой, тэмдэглэлт өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх журам”-ын 1.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Түүхэн тэгш ой тохиож байгаа сум, байгууллагын баяр, наадам тэмдэглэн өнгөрүүлэх товыг хавсралтаар баталсугай.

2.Ойн арга хэмжээг тогтоосон хугацаанд зохион байгуулалтын өндөр түвшинд тэмдэглэж, үр дүнг тайлагнан, тусгай төрлийн баримт, бичгийг бүрдүүлж Төрийн архивд шилжүүлэхийг холбогдох сум, байгууллагын дарга нарт үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Б.Наранбаяр)-д даалгасугай.

ДАРГА



Э.ЭНХБАТ

Аймгийн Засаг даргын 2026 оны 07 дугаар
сарын 04 ний өдрийн А/178 дугаар
захирамжийн хавсралт



ТҮҮХЭН ТЭГШ ОЙ ТОХИОЖ БАЙГАА СУМ,
БАЙГУУЛЛАГЫН БАЯР, НААДАМ ТЭМДЭГЛЭН
ӨНГӨРҮҮЛЭХ ТОВ

Д/д	Сум, байгууллага, түүхэн үйл явдал	Түүхэн тэгш ой	Тэмдэглэх хугацаа
1	2	3	4
1	Баян-Овоо сум	80 жил	2026 оны 07 дугаар сарын 28, 29, 30
2	Шинэжинст сум	70 жил	2026 оны 07 дугаар сарын 27, 28, 29
3	Заг сумын Эрүүл мэндийн төв	100 жил	2026 оны 07 дугаар сарын 9, 10
4	Баянцагаан сумын Эрүүл мэндийн төв	90 жил	2026 оны 07 дугаар сарын 27, 28, 29
5	Богд сумын Эрүүл мэндийн төв	90 жил	2026 оны 07 дугаар сарын 9, 10
6	Өлзийт сумын Эрүүл мэндийн төв	90 жил	2026 оны 07 дугаар сарын 18, 19
7	Жаргалант сумын сургууль	80 жил	2026 оны 07 дугаар сарын 18, 19
8	Баян-Овоо сумын эрүүл мэндийн төв	80 жил	2026 оны 07 дугаар сарын 29, 30, 31
9	Баян-Овоо сумын сургууль	80 жил	2026 оны 07 дугаар сарын 29, 30, 31
10	Шинэжинст сумын сургууль	70 жил	2026 оны 07 дугаар сарын 27, 28, 29
11	Гурванбулаг сумын цэцэрлэг	60 жил	2026 оны 08 дугаар сарын 05
12	Өлзийт сумын цэцэрлэг	60 жил	2026 оны 07 дугаар сарын 18, 19

